




БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ 01 САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Сургуулийн өмнөх боловсрол:

“Тост боржгин бяцхан үрс” хөтөлбөрийн сурталчилах ажлыг 5-р цэцэрлэгийн ЗАН нэгдэлтэй хамтран зохион байгуулсан. Хөтөлбөрийн цахимаар “Сургууль цэцэрлэгийн групп, Говьсүмбэрийн СӨБ групп, цэцэрлэгүүдийн бүлгийн группд байршуулан 632 хүнд хүргэсэн байна.

5 настай хүүхдийн судалгааг шинэчлэн гарган ажиллаж байна. 5 настай хүүхдийг “Сургуульд ороход хэрхэн бэлтгэх вэ” гарын авлагын дагуу цэцэрлэг бүр хамран сургах тойргийн хүүхэд, эцэг эхтэй хамтран ажиллаж байна. Эцэг эхэд гарын авлага, тараах материалыг тараан өгч үр дүнг тооцон ажиллаж байна.

Цэцэрлэгийн 12-эрхлэгч, арга зүйч, 24-багш нартай теле хичээлийн хэрэгжилт, цахим хичээлийг бэлтгэх явцад арга туршлага хуримтлуулсан талаар хэлэлцүүлэгийг зохион байгуулсан.



Ерөнхий боловсролын чиглэл:

Байгууллагын 2021 оны дотоод сургалтын төлөвлөгөө, сургууль, цэцэрлэгийн багш нарт зохион байгуулах сургалтын төлөвлөгөө гаргаж баталгаажуулсан.

Боловсролыг дэмжих хөтөлбөрөөс 4 сая төгрөгний санхүүжилтээр, Элсэлтийн нэгдсэн шалгалтанд бэлтгэх ажлын төлөвлөлт боловсруулан. Аймгийн үнэлгээний шинжээч багш нартай хамтран ажиллах, ажлын төлөвлөлт гарган баталгаажуулсан. 2020 оны ЭНШ ын даалгаврын гүйцэтгэлд, үнэлгээний шинжээч нар дүгнэлт гаргаж, онлайн сургалт зохион байгууллаа. Онлайн сургалтанд, 10 хичээлийн 63 багш, 4

сургалтын менежер хамрагдаж, зөвлөх үйлчилгээ авч, бэлтгэл ажлын санал солилцлоо.

Цэцэрлэг, сургуулийн эрдэм шинжилгээний хурлаас шалгарсан 18 илтгэлийн бичвэрт үнэлгээ өгч, аймгийн эрдэм шинжилгээний хуралд оролцох, илтгэлийг шалгарууллаа.

Багшийн хөгжлийн институтдээс зохион байгуулдаг 1,5,10 багшийн үндсэн сургалтанд цэцэрлэгийн сургуулийн нийт 61 багш бүртгүүлж, баталгаажуулсан. 10 дахь жилийн үндсэн сургалтанд СӨБ-ын 3 багш, ЕБС-ийн 13 багш хичээл сонголтоо хийж, цахим сургалтанд хамрагдаж байна.

Багшийн хөгжлийн институтдээс зохион байгуулж буй онлайн сонголтод сургалтанд ЕБСийн 70 багш, СӨБ-ын 21 хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлж байна. Бага боловсролын байгалийн ухааны хичээлийн 1000 багшийн онлайн сургалтанд, бага ангийн багш нарын 70 хувь тогтмол хамрагдаж байна. Хичээлийн судалгааны нийгэмлэгийн байгалийн ухааны сургагч багш Даваахүү багшийн “Байгалийн ухааны онол арга зүй “сэдэвт төлбөртэй онлайн сургалтанд бага ангийн 15 багш хамрагдаж байна.

Соёл урлагийн чиглэлээр:

Соёлын яамнаас зохион байгуулсан “Хүүхдийн төлөө фонд” байгуулах аянд аймгийн соёл урлагийн байгууллагууд нэгдсэн. Нийт 770,000 төгрөгийн төвлөрүүлж хандивлахаар болсон.

Соёлын салбарын статистик мэдээ боловсруулах, анхан шатны болон, захиргааны маягт бөглөх талаарх цахим сургалтын Соёлын яамнаас 2021 оны 01 сарын 07-ны өдөр зохион байгуулсан. Тус сургалтанд соёлын болон статистик хариуцдаг мэргэжилтэн хамрагдсан.

Соёл, урлагийн байгууллагын удирдлагуудад 2021 оны 01 сарын 10-ны өдөр цахим сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар “Соёлын статистик мэдээ гаргахад анхаарах зүйл”, “Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, удирдлагын менежментийг сайжруулах” чиглэлээр Google from программ ашиглан санал асуулга авч судалгааг дүгнэх, соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагаанд өгөх зөвлөмж сэдвийн хүрээнд мэдээлэл хийж нийт 10 хүн хамрагдсан. Харьяа байгууллагуудаас мэдээллүүдийг хянаж авч байна.


Соёл, урлагийн их сургуулийн Соёлын үйлдвэрлэлийн тэнхимээс 2021 оны 01 сарын 13-ний өдөр зохион байгуулсан “Соёл урлагийн байгууллагад хэрэглэгчтэй харилцах менежмент CRM систем нэвтрүүлэх нь” цахим сургалтанд хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн.

Цар тахлаас сэргийлэх аймгийн онцгой комиссын мэдээлэл сурталчилгааны алба иргэдийг халдварт өвчнөөс сэргийлэх 60 удаагийн

зөвлөмж, цаг үеийн мэдээлэл, видео шторк хийж цахим хуудсанд байршуулж нийт 13900 хүнд хандсан байна.

“Ковид-19” халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор А3-500 ширхэг, А4-300 ширхэг, А5-3000 ширхэг гарын авлагыг бэлтгэн томоохон зах, худалдааны төв хүнсний дэлгүүрүүдэд тарааж, гудамж, байрнуудын гадна талд нааж сурталчилсан.

Корона вирусын тархалтын улмаас өндөржүүлсэн бэлэн байдал зарласан энэ үед соёл урлагийн үйл ажиллагааг цахимд шилжүүлэн ажиллаж байна. Түүхийн танхимын үзмэрийг тайлбарлан видеогоор 1925 хүнд, мөн хэт хутганы талаар тайлбарын хамт цахимд байршуулж 498 хүнд хүргэж цахим соёлын үйлчилгээг үзүүлэн олны хүртээл болгосон.



Тайланг нэгтгэсэн: Бичиг хэрэг Ц.Баярмаа